



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.06.03

№

807

танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн маягт
хүргүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт “Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/47 дугаар тушаалаар “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”-ыг баталсан бөгөөд энэхүү зааврын хавсралт МАЯГТ 1, 2-ын дагуу Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайланг нам, эвслээс ажлын өдрүүдэд 08:30 цагаас 17:30 цаг хүртэл, 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр 08:30 цагаас 00.00 цаг хүртэл Нийслэл дэх Төрийн аудитын газар хүлээн авна.

Энэхүү албан бичгийн хавсралтаар хүргүүлж буй Маягт 1,2-ын дагуу хандивын тайлангаа үнэн зөв, холбогдох мэдээллийг бүрэн тусгасан байдлаар, дүгнэлт гаргуулахад шаардлагатай дараах баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр хуульд заасан хугацааны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар /Соёлын төв өргөө “Г” корпус 6 давхар 615 тоот/-т хаяглан битүүмжлэн ирүүлнэ үү. Үүнд:

- Намын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;
- Нам, эвсэлд нэгдэн орсон намуудын 2023 оны санхүүгийн жилийн эцсийн аудитлагдсан тайлан;
- Харилцагч банкны баталгаажуулсан дансны хуулга (2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх) банкны тодорхойлолт /данс бүрээр/.

Хандивын тайланд намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн татвар, хандивыг хамруулахгүй.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд аливаа байдлаар тусгагдаагүй орхигдсон эсхүл мэдээлээгүй хандивыг Нийслэл дэх Төрийн аудитын газар хянан баталгаажуулаагүйд тооцох ба үүсэх үр дагаврыг хариуцахгүй болно.

002022215

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь хандивын тайланг хянаж, дүгнэлт гаргах явцад нам, эвслээс ирүүлсэн мэдээллийн хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг баримтлан ажиллах бөгөөд хүргүүлсэн маягт болон холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, лавлагаа шаардлагатай бол Аудитын удирдлага зохицуулалтын хэлтсийн 31-55-78 дугаарын утсаар холбогдох боломжтой. Хугацаа хоцроосон хандивын тайланг хүлээн авах хуулийн зохицуулалт байхгүй болохыг анхаарна уу.

Хавсралт: 2 . хуудастай.

Хүндэтгэсэн:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан
баталгаажуулж, дүгнэлт гаргах зааврын хавсралт
МАЯГТ-1

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд
" ИРГЭНЭЭС "-ээс өгсөн хандивын тайлангийн маягт
...../нам, эвслийн нэр/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон										
1										
2										
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд										
1										
2										

Санамж: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй

Тамга тэмдэг
тэмдгээр баталгаажуулна./

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга

Хянасан
албан тушаал

.....
овог нэр

/...../
гарын үсэг

.....
огноо

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан
баталгаажуулж, дүгнэлт гаргах зааврын хавсралт
МАЯГТ-2

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд
“ХУУЛИЙН ЭТГЭЭД”-ээс өгсөн хандивын тайлангийн маягт
...../нам, эвслийн нэр/

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл					Хандив хүлээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар
		регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр	Дансны дугаар		
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон											
1											
2											
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд											
1											
2											

Санамж: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй

Тамга тэмдэг
тэмдгээр баталгаажуулна./

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга

.....
албан тушаал

.....
овог нэр

/...../
гарын үсэг

.....
ОГНОО